



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 1409

Баян-Овоо

Эд хөрөнгийн тооллого зохион байгуулж,
комисс байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1, 72 дугаар зүйлийн 72.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын эргэлтийн хөрөнгийн болон үндсэн хөрөнгийн эхний хагас жилийн тооллогыг 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 21-ний өдөр хүртэл зохион байгуулсугай.

2. Эд хөрөнгийн тооллого явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулсугай.

Комиссын дарга
Нарийн бичгийн дарга
Гишүүд

О. Насанжаргал (Хөгжмийн багш)
Б. Эрдэнэчулуун (Номын санч)
Б. Бат-Эрдэнэ (Музейн ажилтан)

3. Эд хөрөнгийн тооллогын бэлтгэл хангах, анхан шатны хөтлөлт, тооллогын бүртгэлийг баталгаажуулах, агуулахын эмх цэгц, хадгалалт хамгаалалтыг сайжруулан тооллогыг тогтоосон хугацаанд чанартай явуулж дуусгахыг комисст үүрэг болгосугай.

ДАРГА



Ш. ГАНГАНТУУЛ